



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 дугаар сарын 08

Дугаар 11/05

Баян-Өндөр сум

┌ Эрдэнэт сангийн орлогоос 2023 онд ┐
санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн
зардлын тодотгосон жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутаг хөгжүүлэх Эрдэнэт сангийн орлогоос 2023 оны санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлын тодотгосон жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Ээлжит бус XI хуралдааны 1110 дугаар тогтоолын хавсралт



Эрдэнэт сангийн орлогоос 2023 онд санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлын тодотгосон жагсаалт

(мян.төгрөг)

ОРЛОГО					
№	ТӨРӨЛ	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1	Реклам, сурталчилгааны самбараас орох орлого	2023	2023	16,085.0	16,085.0
2	ГБХЗХГ-ын үйл ажиллагааны орлого	2023	2023	35,000.0	35,000.0
3	ГХБХБГ-ын үйл ажиллагааны орлого	2023	2023	90,360.0	90,360.0
4	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 2020 оны хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	2020	2023	2,921,311.2	2,921,311.2
5	Урьд оны шилжих үлдэгдэл	2022	2023	4,209,185.5	1,732,808.3
ОРЛОГЫН ДҮН				7,271,941.7	4,795,564.5
ЗАРЛАГА					
№	ТӨРӨЛ	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1	Эрдэнэт сангийн ажилтны үйл ажиллагааны зардал	2023	2023	10,419.3	10,419.3
2	ГБХЗХГ-ын үйл ажиллагааны зардал	2023	2023	35,000.0	35,000.0
3	ГХБХБГ-т цахим үйлчилгээний киоск машин худалдан авах	2023	2023	47,000.0	47,000.0
4	ГХБХБГ-т архивын нягтруулсан шүүгээ худалдан авах	2023	2023	14,250.0	14,250.0
5	ГХБХБГ-т тоног төхөөрөмж худалдан авах	2023	2023	24,720.0	24,720.0
6	ГХБХБГ-т техник хэрэгсэл худалдан авах	2023	2023	4,390.0	4,390.0
7	Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт	2020	2023	1,629,095.0	528,942.8
8	"Цэцэрлэгт хүрээлэн"-ийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт	2021	2023	1,875,000.0	543,524.7
9	Эрдэнэ багийн усан санд өргөлтийн насос нэмж суурилуулах	2020	2023	74,500.0	18,689.9
10	Үерийн хамгаалалтын суваг хийх ҮХС-4 / үргэлжлэл - 1510 м/	2021	2023	112,256.2	11,316.5
11	Найрамдал өндөрлөг, Их шүтээн цогцолборын авто зогсоол, гэрэлтүүлэг, тохижилтыг сэргээн засварлах	2022	2023	524,000.0	524,000.0
12	Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил	2020	2023	2,921,311.2	2,921,311.2
13	Баяр наадмын үйл ажиллагааны нэмэлт санхүүжилт	2023	2023	112,000.0	112,000.0
ЗАРЛАГЫН ДҮН				7,383,941.7	4,795,564.5